

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ  
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234706

ЗАЯ БАНДИДА НАМХАЙЖАМЦЫН ОРЧУУЛГЫН  
ЗОХИОЛЫН ҮГСИЙН САНГИЙН ОНЦЛОГ<sup>1</sup>  
(хуучин үгийн жишээн дээр)

Х.Бямбажав

Түлхүүр үг: үгийн сан, хуучин үг, Зая бандида Намхайжамц, тод бичгийн дурсгал

Оршил

Монгол уламжлалт орчуулгын зохиолууд нь монгол хэлний түүхийн үе үеийн онцлогийг тодруулахад чухал хэрэглэгдэхүүн болдог билээ. Ялангуяа нэг орчуулагчийн олон тооны орчуулгын бүтээл нь түүний орчуулгын хэлний тогтолцоог гаргах, орчуулгын ур чадварыг нь тогтоох тодорхой баримт юм.

XVII зууны эхэн үеийн монгол орчуулагчдын гол төлөөлөгчийн нэг бол Ойрадын Зая бандида Намхайжамц (1599-1662) бөгөөд тэр бээр төвөд хэлнээс 180 гаруй зохиолыг орчуулсан байна. Тэдгээрээс өдгөө 100 гаруй зохиол нь мэдэгдэж буй ба орчуулагч нь тодорхойгүй олон тооны тод бичгийн дурсгалыг орчуулсан байж магадгүй хэмээн судлаачид үздэг. Бидний энэхүү судалгаа орчуулгын зохиолын хэлний онцлогт тулгуурлан орчуулагчийг тодруулахад хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна. Өөрөөр хэлбэл, түүний орчуулгын талаарх судалгааг үзвэл ихэвчлэн төгсгөлийн шүлгүүдийнх нь хэм хэмнэл, яруу найргийн онолын асуудал голлон анхаарч харин орчуулсан бүтээлийнх нь хэл, түүний үгийн санд төдий л анхаарал хандуулалгүй өнөөг хүрч ирсэн байна.

Аливаа орчуулгын бүтээл нь тухайн хэлний тодорхой үеийн баримт, түүхэн хэл шинжлэлийн судлагдахуун болохын зэрэгцээ уг хэлний үгийн санг сэргээн баяжуулах, эртний монгол хэлний үгийн сангийн онцлог шинж хэрхэн хадгалагдсаныг шинжлэн тогтооход чухал ач холбогдолтой юм.

Бид өмнө нь “Зая бандидын орчуулгыг төрөл зүйлээр ангилах нь<sup>2</sup>”, “Зая бандида Огторгуйндай ба түүний шавь нарын орчуулгын бүртгэлийг судалсан тойм<sup>3</sup>” гэсэн сэдвээр эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцүүлж түүндээ Зая

<sup>1</sup> Characteristic in the vocabulary of Zaya pandita Namkhajamts’s translated literary monuments (on the example of archaic words)

<sup>2</sup> Илтгэлийг 2018 оны 06 сарын 22-д Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Тод үсэг-370” олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлж мөн *Bibliotheca oiratica-LXXVII*. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Уб., 2018:36-44-д хэвлүүлсэн буй.

<sup>3</sup> Илтгэлийг “Тод үсэг-375” олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлж *Bibliotheca oiratica-CXXI*. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Уб., 2023:51-65-д хэвлүүлсэн буй.

бандида Намхайжамцын өдгөө мэдэгдээд буй 100 гаруй орчуулгын дурсгалыг агуулгын хувьд гүн ухаан, сургаал, анагаах ухаан, дуун ухаан, зурхай, түүхийн сэдэвт хамаарагдаж байгааг, мөн түүний орчуулсан ямар ямар бүтээл өнөө мэдэгдээд буй талаар тодорхой өгүүлсэн билээ. Энэ удаа бид тэдгээр бүтээлийн үгийн санг анхааран үзэж хуучирсан үгийн талаар тусгайлан авч үзсэн юм. Учир нь Зая бандида Намхайжамцын орчуулгын хэлэнд тохиолдож буй боловч өнөөгийн аман ба бичгийн хэлэнд нэгэнт хэрэглэгдэхээ больж, утга нь тодорхойгүй болсон үгс цөөнгүй байна. Монгол хэлний үгийн сан судлалын бүтээлд “орчин цагийн монгол аман ба бичгийн хэлнээ идэвхтэй хэрэглэгдэхээ больсон үгсийг хуучирсан үг гэнэ” (ОЦМХҮССҮ. 1986:51) хэмээн тодорхойлсон байх ба дотор нь: 1. Эртний үг, 2. Түүхэн үг, 3. Хуучирсан үг гэж ангилан үзжээ. Харин бид Зая бандида Намхайжамцын орчуулгын бүтээлийн хэлний үгийн санг нэгтгэн судалсны дүнд уг үгийн санд тохиолдох “орчин цагийн монгол аман ба бичгийн хэлнээ идэвхтэй хэрэглэгдэхээ больсон үгсийг” *эртний үг, хуучирсан үг* гэж хоёр зүйлд ялган үзэх боломжтой хэмээн үзсэн юм. Ингэхдээ бид *эртний үг* гэдэгт дундад үеийн монгол хэлний бичгийн сурвалжуудад тэмдэглэгдсэн ч орчин цагийн монгол бичгийн хэл болон бусад аялгуу, аман аялгуунд хэрэглэгдэхээ больсон, одоо нэгэнт ойлгогдохгүй болж мартагдсан эс бөгөөс утга нь хувирсан үгсийг, *хуучирсан үг* гэдэгт тухайн юм, үзэгдэл, ойлголт нь байгаа атал ойролцоо утга бүхий өөр үгэнд шахагдан идэвхтэй хэрэглэгдэхээ больсон, орчин цагийн монгол аман ба бичгийн хэлнээ тэр бүр тохиолдохгүй болж идэвхгүй үгийн санд шилжсэн үгсийг тус тус авч үзсэн билээ. Тэдгээр үгсийн утгыг тодруулахдаа бид уг зохиолыг орчуулахад баримталсан төвөд эхийг тогтоон олж харьцуулснаар төвөд үгийн утгыг бусад монгол орчуулга болон төвөд-монгол хэлний толь бичиг зэргээс тодруулан тогтоосон болно. Ер нь Зая бандида Намхайжамц орчуулгын зохиолдоо тухайн үедээ идэвхтэй хэрэглэгддэг байсан үгсийг ашиглаж байсан гэдэг нь мэдээж бөлгөө. Гэвч цагийн уртад олон үгийнх нь утга бүдгэрч, хэрэглээ орхигдож их, бага хэмжээгээр идэвхгүй болсон байна. Жишээ нь, төвөдийн *rengs pas* хэмээх үгийг Зая бандида Намхайжамцын орчуулсан Субашидад *mons motourxaqsan-yēr öbör busudi jobōxu* [Муус *мотуурхсанаар* өөр бусдыг зовоох] (Лувсанбалдан 1976:74) гэж, харин уг зохиолын хамгийн эртний монгол орчуулга болох Сономгарагийн орчуулгад *mayus örilcegsen-iyer bügüde-yi jobayayu* [Муус *өрөлцсөнөөр бүгдийг зовооюу*] (Kara, 2009:220) гэж орчуулсан байна. Өдгөө энэхүү *motourxaqsan* гэсэн үгийн утга тодорхой үгүй болсон боловч Сономгара гүүш ‘өрөх зөрөх’ гэсэн утгаар орчуулж, мөн төвөд-монгол хэлний толь бичигт *rengs pa* нь ‘хэдэрлэх, хөшүүн зөрүүд зан гаргах’ гэж оноожээ. Иймд бид Зая бандидын орчуулгад буй *motourxaqsan* хэмээх үг нь *motou* гэсэн нэрийн язгуурт *-rxa* гэсэн үйл үг бүтээх дагавар залгаж бүтээсэн зан авир, үйл хөдлөлийг заасан үйл үг хэмээн тогтоож болохоор байна.

## 1. Эртний үг

Дээр тодорхойлсны дагуу дундад үеийн монгол хэлний дурсгалд олонтоо тэмдэглэгдсэн зарим үг, хэллэг Зая бандида Намхайжамцын орчуулгын зохиолд

цөөн боловч тохиолдож байна. Энэ үеийн монгол хэлний дурсгалын талаар Д.Төмөртоогоо “Эдүгээ бидэнд уламжлан үлдсэн уйгуржин монгол бичгийн дурсгалууд нь бүтээгдсэн цаг хугацааныхаа хувьд XIII-XVI зууны үед холбогдох боловч түүнд туссан хэлний бодит шинж нь лавтайяа IX-X зууны монгол хэлний шинжийг тусгаж байгаа билээ. Өөрөөр хэлбэл, тэдгээр нь эртний монгол хэлний сүүлч үеийн онцлог шинжийг тусгасан дурсгалууд юм. Харин дөрвөлжин, араб, хятад үсгээр тэмдэглэсэн бусад дурсгалууд нь цөм дундад үеийн монгол хэлний үндсэн шинжийг тусгасан байна” (2011:6) хэмээн тодорхойлжээ. Тиймээс Зая бандида Намхайжамцын орчуулгын бүтээлүүд XVII зууны эхэн үед холбогдох боловч түүний хэлний үгийн сангийн бүрэлдэхүүнд эртний монгол хэлний онцлогийг тусгасан үгс уламжлагдсан байна. Жишээ нь:

#### ***asa-***

Зая бандида Намхайжамцын орчуулгад:

***asaxu*** (асуух) *tālaliyin onisu ene metü asaxu kereqtei kemēqsendü* [тааллын оньс энэ мэт асуух хэрэгтэй хэмээсэнд] (НГ. 157.v24)

***asaxui*** (асуухыг) *üčüken asaxui durašibaču* [өчүүхэн асуухыг дуршивч] (BSYOI.5r)

***asaq*** (асуу) *busu yeke biliqten-ēče sayitur asaq...* [бусад их билигтнээс сайтар асуу] (SNES. 312)

***asaqba*** (асуув) *ikir čikir ali bui kemēn ese asaqba* [ихир чихир аль буй хэмээн эс асуув] (НГ. 116r19)

***asaqsu*** (асуусу) *küsel edleküi čaq-tu asaqsu či sedkildü toqtō* [хүсэл эдлэхүй цагт асуусу, чи сэтгэлд тогтоо] (НГ. 157.v27)

***asayūqsan*** (асуусан) *öbörön üjen sonosun asayūqsan-ni küčün-dü šütüji* [өөрөө үзэн сонсон асуусны хүчинд шүтэж] (BSYOI. 5r6)

***asūl ügei*** (асуулгүй) *kejē temečen asūl ügei. tejīyēde mergeni kira čaqlaxu ügei* [Хэзээ тэмцэн асуулгүй тэжээд мэргэний хир цаглахгүй] (SNES. 6)

Дундад үеийн монгол хэлний дурсгалд:

*dumda ke'elitei eme-yi bariju ya'ujin gü'ün či ke'en hasaba* [дунд хэвэлтэй эмийг барьж юужин хүн чи хэмээн асуув] (MNT. §38)

*Tayang qan jamuqa-dača asaqurun te'ünü qoyinača ayisuqun ken büyyü ke'eju'üi* [Таян хаан Жамухаас асуухдаа түүний хойноос айсах хэн буй хэмээжээ] (MNT. §195)

*üčügüken asaysuyai kemen küsebesü ele* [Өчүүхэн асуусугай хэмээн хүсвээс л] (BT. 163a3)

*Asayu:lčan* *temečeldüge: inaysida mergen-i uqan ülü čidayu.* [Асуулцан тэмцэлдэхээс нааш мэргэнийг ухан үл чадах] (Sub. I:4b)

#### ***büdü***

Энэ үг Зая бандидын орчуулгын дурсгалуудад олонтоо тохиолдох ба төвөд хэлний *dn̄gos ro; ngo bo; gsha' ma* “бодтой, жинхэнэ, гол, мөн чанар, бие бүхий

юм” гэсэн утгатай үгийг ийнхүү орчуулсан байна. Монгол бичгээр энэ үгийг *büdüin* гэж бичих боловч ö/ü, d/t авиаг адилхан тэмдэглэдгээс орчин цагийн монгол хэлэнд “бүтэн” хэмээн хөрвүүлэх болжээ. Иймээс “Лу. Алтан товч” дахь Чингис хааны билиг сургаалын хэсэгт буй “...бүтэн бие минь зовбоос зовтугай” гэсэн хэллэг угтаа бүдүн бие байх боломжтой юм.

Зая бандида Намхайжамцын орчуулгад:

töüni tula büdüin beyeyin uċir-tu sudulxuyin yoson (BMÜ.90v35)

Дундад үеийн монгол хэлний дүрсгалд:

Монголын нууц товчоонд энэ үг 不敦 (*bü dün*) гэсэн хэлбэрээр 本 (бодит, уг, гол, чухам, жинхэнэ) гэсэн утгаар тохиолдож байна. Жишээ нь:

bo’ol nekün büdüin ejen-iyen bosoju nendeju bariqu bolba [Боол нэхүн бүдүн (жинхэнэ) эзнээ босож нэндэж барих болов] (MHT. §200)

büdüin beye’en buru’udun bugiya moritu buqu-yin horum horumlaju [Бүдүн (бодот) биеэ буруудан бугиа морьт бугын ором оромлож] (MHT. §103)

### ***ċimad-***

Төвөд хэлний *sting ba*; ‘*khang*; ‘*khun* ‘*tshor ba* хэмээх донгодох, зэмлэх, зүхэх зэрэг утгатай үгсийг ийнхүү орчуулжээ. “*ċimad-*”-ын авиа хувьссан хэлбэр нь *ċimed*, *ċimedkebei* (Tib. *spyos ba* – донгодох, зандрах, зэмлэх (Тэрбиш, 2018, 920) гэж тохиолддог.

Зая бандида Намхайжамцын орчуулгад:

*ċimadun* (Tib. *sting ba*) *eleqlen* yutān üyiledün *doromjilon* *ċimadun* üyiledün (NMŠ. 282r)

*ċimadxal* (Tib. ‘*khun* ‘*tshor ba*) *touji* sonosxulā *ċimadxal* öüskeqči (SNES. 101)

Дундад үеийн монгол хэлний дүрсгалд:

Činggis qahan Joči Ča’adai Ögödei qurban kö’üd-i *ċimatču* qurban üdür ese a’ulja’ulba (MNT. §260)

Nasu *ċimadun* yabuyči sadud-ta edüi tedüi ögči üldegdeküi (SRN. 359a)

Энэ үгийг Зая бандида Намхайжамц нэг удаа гомдох, гонсойх, уурлах гэсэн утгатай бүхий “*өлөмтөх*” (*ölömtöküi* SNES.359) гэдэг үгээр орчуулсан нь бий.

### ***ċolo***

Төвөд хэлний *sgo skabs*; *dal* ‘*byor* буюу зав чөлөө, завшаан, боломж, зол учрал гэсэн утгатай үгсийг ийнхүү орчуулжээ. Зарим үед мөн “учир үе” гэж төвөд үгийг хуулбарлан орчуулсан байна.

Зая бандида Намхайжамцын орчуулгад:

dēdū nom бүтөкү *ċolo* ügei (SNES. 436)

erdeni *ċolotu* uċiral sayitur tögüsüqsen (PR. Col.)

nayiman *ċolo* ügei (AG.15v19)

*ċoloyin* xān (AG.15v20)

Дундад үеийн монгол хэлний дурсгалд:

čole [=čöle] BT. 156b7, 161b2; Bur. 39b(2); Sub. V:12a, VIII:4b, IX:11a

“Бодичарьяавадара”-г судалсан эрдэмтэд энэ үгийг čole-tü [161b2] хэмээн уншиж галигласан байна (Cleaves 1954, 59; Tumurtogoo, 2011:357). Ингэхдээ орчин цагийн монгол хэлний *чөлөө* (čilüge), *чөлөө учрал* (čilüge učaral) гэх үгийн дуудлагад ойртуулсан бололтой. Харин гүүш Сономгарагийн Субашидын орчуулгад **čola** Sub.V:12a, VIII:4b, (nom-i бүтүгекүй čola qamiγ-a bui) гэж тэмдэглэсэн нь бий. Мөн *К.Ф.Голстунский толь бичигтээ энэ үгийг čola, čolo (чоло, чилүгэ) гэж тодорхой ялган тэмдэглэжээ (1893:295b). Харин бидний бодлоор тод бичгийн дурсгалууд болон сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалууд дахь čolo, čola (чол) гэдэг энэ үг орчин цагийн монгол хэлний зол (jol) гэдэг үгтэй утга ба дуудлагын хувьд ихээхэн ойролцоо юм.*

### **еcүй-**

Төвөд хэлний *nub ba, tshar bcad pa, bcom pa* буюу *дарах, мөхөөх, номхотгох* гэсэн утгатай үгсийг Зая бандида Намхайжамц *еcүидгекүй, еcүilkүй* гэж орчуулдаг.

Зая бандида Намхайжамцын орчуулгад:

**еcүilүн** (эцлэн) šumnuši **еcүilүн** üyiledküi [Шумнусыг эцлэн үйлдэх] (SNES. 159)

**еcүilkүй** (BMÜ. 9v14) - эцлэх

**еcүidкүй** (эцдэх) dalai-du mören öböriyin beye-dü šinggen **еcүidкүй** boluyu [Далайд мөрөн өөрийн биед шингэн эцдэх болуу] (NG.159r)

**еcүidкекүй** (SNES.159) - эцэдгэх

Дундад үеийн монгол хэлний дурсгалд:

eme kö'ün inu **еcүiltele** hawuluya [эм, хөвүүдийн эцэлтэл уулаяа (уулгалаа)] (MNT. §105)

eme kö'ü inü **еcүiltele** dauliba [эм, хөвүүдийн эцэлтэл дуулив (дагуулив)] (MNT. §109)

Da'aritai Gereyit-lu'a bolulčaba ke'en nidün-ü еcüne **еcитгеуе** ke'ebesü [Дааритай Хэрэйд лугаа бололцов хэмээн нүдний эчнээ эцэтгээ хэмээвээс] (MNT. §242)

### **γarxu, γartaxu**

Зая бандида Намхайжамцын орчуулгад:

**γarxu** (ялах, дийлэх) onomoγoi oyoutai buya xurāqsan kümün: γaqčār bolboči xamugi **γarxu** [Ономгой оюутай буян хураасан хүн гагцаар боловч хамгийг γарax.] (SNES. 159)

**γartaxu** (ялагдах, дийлдэх) ta хойор ilγal üyiledči ali **γaruqsan**-du **γartaqsan** čečeq erike örgün: ali **γartaqsan** ende bü sou kemēn jarliq boluqsan-du: [Та хоёр ялгал үйлдэж аль γарсандaa γартсан нь цэцэг эрих өргө. Аль γартсан нь энд бүү суу хэмээн зарлиг болсонд] (NG. 184r)

**γartaqsan** (ялагдсан, дийлдсэн) (NG. 184r)

Дундад үеийн монгол хэлний дүрсгалд:

kerbe *yartabasu* nöküd degen čimaduу [хэрвээ гартваас нөхөртөө чимадую] (Sub. III:11a)

hontučaju čimada *qarda'asu* heregey-yen hoqtolju o'orsuqai abalduju čimada ilaqda'asu unaqsan qajar-ača bü bossuqai [Онтцож (харвалцаж) чамд гартваас эрхийгээ огтолж оорсугай, авалдаж (барилдаж) чамд ялагдваас унасан газраас бүү боссугай] (MNT §254)

### *gere*

Төвөд хэлний *zhun mar* гэдэг үгийг ийнхүү орчуулжээ. Ташрамд дурдахад *zhun mar* (тосон дэн) хэмээх төвөд хэлний энэ үг шумар гэсэн хэлбэрээр ойрад аялгуунд орж гэрэл гаргах тосон дэнг нэрлэсээр байна. Харин Зая бандида Намхайжамц *gere* гэж монгол бичгийн хэлэнд уламжлан хэрэглэгдсээр ирсэн үгээр орчуулсан ажээ.

Зая бандида Намхайжамцын орчуулгад:

*gere* saba-du talbixula : sabāgi xuluуuna ülü jouxu buyu [Гэрэ савд талбихлаа савыг хулгана үл зуух] (SNES.389)

Дундад үеийн монгол хэлний дүрсгалд:

ene kö'ün činü

nidün-tür-iyen qaltu

ni'ur-tur-iyen *geretü* kö'ün büi

[Энэ хөвүүн чинь

Нүдэндээ галт

Нүүрэндээ гэрэт (гэрэлт) хөвүүн буй] (MNT §62)

### *nauidangyui*

Буддын шашинд сэтгэлийн таван муу хорын нэг атаат сэтгэлийг төвөдөөр *phrag dog* хэмээдэг бөгөөд Зая бандида Намхайжамц бээр ийнхүү орчуулжээ. Атаархах сэтгэл гэсэн утгатай энэ үгийг мөн заримдаа үзээ ядах (*üjē yadxu* НГ.2v) гэж орчуулсан нь бий.

Зая бандида Намхайжамцын орчуулгад:

*nauidangyui* ügei eneriküi-tü dalaі onbu čāsun-du bičibeі. [Найдангуй үгүй энэрэхүйт Далай омбо цаасанд бичив.] (ТČ. Col.)

jarim medebečü *nauidangyui* törön doromjiloboi [Зарим мэдэвч найдангуй төрөн доромжлов] (НГ.158v)

Хэлзүйн хэлбэрийн хувьд Зая бандида Намхайжамц хутагт *nauidangyui* гэсэн нэг л хэлбэрээр тогтвортой орчуулсан бол харин дундад үеийн монгол хэлний дүрсгалд *nauidaba*, *nauidaju*, *nauyitaqdamu*, *naui:daysan*, *naitamu*, *naitagdan* гэх мэт хэлбэрээр тохиолддог.

Дундад үеийн монгол хэлний дурсгалд:

nada urida bosču ūqdarun *naɣyidaba* ʃe čī (MNT. §179)

namayi ücügen čaq-tur Таууиči'ud-un Tarqutai-kiriltuq aqa de'ü-de *naɣyitaɣu* bari'asu tende aqa de'ü-de'en *naɣyitaqdamu* (MNT. §219)

öbe:r-ün ed-ıye:n barayı:lqu-yi:n tulada öbe:r-tege:n kü *naɣi:daysan* bolun buyu (Sub. IX:7b11)

### ***tejıyēde***

Төвөд хэлний *de srid du; de yi bar du* буюу *тэр үед, тэр болтол* гэсэн утгатай үгийг эртний монгол орчуулгуудын адил ийн орчуулдаг.

Зая бандида Намхайжамцын орчуулгад:

keǰē ičöüri bui bolxulā. *tejıyēde* erdem čimegiyin dēdü (SNES. §123)

***Сономгарагийн орчуулгад:***

keǰıyede ičegüritü bolbasu ele. *tejıyede* erdem čimeg-üd-ün degedü (IV:7a. Ligeti 1948, 37.)

Зая бандида Намхайжамцын орчуулгад:

keǰē oqtorıyui orošixui kigēd

amitan keǰē orošixu

*tejıyēde* bi orošin üyiledǰi

amitani jobolong arilyaxu boltıyai (BSYOY. 5a14)

Чойжу-Одсэрийн орчуулгад:

keǰıy-e: oytoryui atala

amitan keǰıy-e: aqu bolba:su

*tejıy-e:-de* bi ber aǰu bürün.

amitan-u jobolang-i arilyaqui boltıyai:.. (BT. 163b. Tumurtogoo 2006, 56)

### ***töridküi***

Дундад үеийн монгол хэлний дурсгалд *töritčü* (MNT §193), *töritgerün* (MNT. §197), *töritge'esü* (MNT. §145), *töridküi* (Turf. 12:11), *töridčü* (Bur. 6a) гэсэн хэлбэрээр тохиолддог үгийг тод бичгээр *töridküi* гэж бичих ба *саатуулах, түдээх, боох* гэсэн утга илэрхийлдэг нь хэлбэр, утгын хувьд бүрэн тохирч байгаа юм.

### ***udurilsu***

Төвөд хэлний *khrid* ‘хөтөлбөр’, *lung khrid* ‘эш хөтөлбөр’ гэсэн утгатай үгийг *udurilsun* ‘удируулс’ гэж орчуулан *udıxui*, *udurilsu*, *uduriılsu* гэсэн хэлбэрээр тэмдэглэжээ.

*udurilsu* (BMÜ.65v) (Tib. *lung, khrid*) - эш хөтөлбөр

*udıxui udxa* (NG.14r) (Tib. *drang don*) – Гүн ухааны нэр томьёо *янагуух утгыг удирдах утга* гэж орчуулжээ. Энэ нь Зая бандидын орчуулгад тогтсон нэр томьёо болон хэвшсэн байна.

Хуушаанаас бясалгалын удриулс авч ирэхэд бэлэг өргөв. (NT. 181r)

XIV зуунд Сономгара үүнтэй ижил *khrid pa na* –хөтөлж, дагуулж гэдэг үгийг uduridtaju гэж орчуулсан байна (Sub.VII:9a).

jarči'udai ebügen kü'ürge-ben ürçü jelme neretü kö'un-iyen uduritcu irejü [Жарчуудай өвгөн хөөргөө үүрч Зэлмэ нэрт хүүгээ удирдаж ирж...] (MNT. §97)

jebe ügülerün ani uduju gödölgejü ire'ülün tende soriya ke'ejü qaribai [Зэв өгүүлрүүн: Аныг (тэднийг) удуж (хөтөлж) ирүүлэн тэнд сорьё хэмээж харив] (MNT. §247)

Сонгодог монгол бичгийн хэлэнд *хөтөлбөр*, *хөтлөх*, *дагуулах* гэж үгийн сангийн утга хувираагүй ч хэлбэрийн ялгаатай болсон энэ үг Зая бандидын орчуулгын хэлэнд эртний утгаа алдаагүй хэвээр хэрэглэгдэж байжээ.

## 2. Хуучирсан үг

Зая бандида Намхайжамцын төвөд хэлнээс орчуулсан зохиолуудын үгийн сангийн дотор өдгөө тухайн юм, үзэгдэл, ойлголт нь байсаар атал ойролцоо утга бүхий өөр үгэнд шахагдан идэвхт чанараа алдаж аман ба бичгийн хэлнээ тэр бүр хэрэглэгдэхээ больж нэгэнт идэвхгүй үгийн санд шилжсэн үг, хэллэг нэлээд бий. Тийнхүү хуучирсан үгийн бүрэлдэхүүнд орсон үгсийг хэрэглээ, утгаар нь бүрмөсөн мартагдсан, мартагдаж байгаа, мартаагүй боловч хэрэглэгдэхгүй байгаа үгс гэж тухайн үгийн идэвхтэй үгийн хүрээнээс гарсан цаг хугацаагаар ангилан үзэж болно. Тухайлбал, Зая бандида Намхайжамцын орчуулгын зохиолын үгийн сангийн хуучирсан үгийг ажиглан үзэхэд харилцан адилгүй шинж чанартай байна. Жишээ нь, *тумгах* (*tumaxu*), *хусар* (*xusara*), *хитуун* (*kituun*) мэт үг орчин цагийн аман ба бичгийн хэлэнд огт хэрэглэгдэхээ больсон бол *өм* (*ömö*) гэдэг үг “өмөг, өмөөрөх, өмгөөлөх”, *хөөлүүр* (*kölöür*) гэдэг үг “хөөмий, хоолой” гэх үгийн бүтцэд тохиолддог. Харин зарим үг нь орчин цагийн монгол утга зохиолын хэлэнд хэрэглэгдэхгүй болсон боловч нутгийн аялгуунд хэрэглэгдсээр байна. Жишээ нь, *хохирим* (*xokirim*) – ‘хүйтэн хавсарга’, *уу* (*ou*) – ‘уудам агуу’, *ямаар* (*ymāru*) – ‘хэрхэн яаж’, *цэхэм* (*čekim*) – ‘омог’, *бөчир* (*böčir*) – ‘мөчир’, *бах* (*baха*) – ‘хүсэл шунал’, *ясах* (*yasaxu*) – ‘засах’ г.м.

Бас язгуур нэг боловч бүтээврээр хэлбэржсэн хэлзүйн хувиллаар утга нь орчин цагт ухагдахгүй, түгээмэл бус үгсийг хуучирсан үгийн хүрээнд авч үзэв. Жишээ нь,

*цөөлөг* (Tod. cölöq, Tib. thor bu) – хэсэг бусаг, тархмал  
*хэнхэх* (Tod. kengkekü, Tib. myos pa) – хэсэх, бядах, гүйх  
*зугаалахуй* (Tod. juälaxui, Tib. ka gsag) – зусардах

Түүнчлэн Зая бандида Намхайжамцын орчуулгын зохиолын үгийн санг судлах явцад ажиглагдсан нэгэн сонирхолтой зүйл нь үгийн утга өөрчлөгдөн эсрэг утга илэрхийлэх болсон явдал байв. Жишээ нь,

*төсөр* (Tod. töśör, Tib. rgyang) – ‘хол, алс’ гэсэн утгатай байсан энэ үг орчин цагт *ойр*, *дөхөм*, *хямд*, *үнэ багатай* гэсэн утгаар,

*найжнар* (Tod. nayjinar, Tib. bud med) – ‘эхнэр, бүсгүй’ гэх утгатай байсан энэ үг орчин цагт *анд*, *нөхөд* гэх утгаар,

*тоорцог* (tōrčoq) – ‘дэлбээ, цоморлог’ гэх утгаар хэрэглэгдэж байсан энэ үг одоо зөвхөн үндэсний нэг зүйл малгайн нэр болон тус тус өөрчлөгджээ.

Мөн үгийн утга явцууран, тодорхой болсон нь ч бий. Жишээ нь, *золгох* (Tod. jolyoxu, Tib. phrad pa) – ‘золгох’ гэдэг үг нь дундад үеийн монгол хэл болон Зая бандида Намхайжамцын орчуулсан тод бичгийн дурсгалуудад *уулзах, учрах, тохиолдох, тааралдах* зэрэг өргөн утга илтгэж байсан бол өдгөө зөвхөн хүмүүс харилцан гар зөрүүлж ёслон мэндлэхийг заасан утгатай болжээ. Түүний зэрэгцээ тухайн үед монгол хэлээр орчуулан хэрэглэж байсан зарим үгийг хожим шууд төвөд хэлний үгээр нь нэрлэн хэрэглэж хэвшсэн тохиолдол ч цөөнгүй харагдана. Жишээ нь,

ulamiyin üye ‘улмын үе’ (Tib. go rim) > ‘горим’.  
touji ‘тууж’ (Tib. rnam thar) > ‘намтар’.

Зая бандида Намхайжамцын орчуулсан зохиолуудын хэлийг судлан үзэхэд үгийн утга мартагдсан, хуучирсан, өөрчлөгдсөн, явцуурсан зэрэг үгийн сангийн олон үзэгдэл явагдсан нь ажиглагдсан бөгөөд бид энэ удаад эртний үг, хуучирсан үг хоёрыг тусгайлан авч хэрхэн утгыг тодруулах талаар танилцууллаа. Цаашид Зая бандида Намхайжамцын орчуулгын зохиолын үгийн сангийн дээрх олон үзэгдлийг тус бүр нарийвчлан судалж тогтолцоог тодруулан гаргахаар ажиллаж байгаа болно.

## Дүгнэлт

Зая бандида Намхайжамцын төвөд хэлнээс орчуулсан зохиолын хэл нь XVII зууны үеийн монгол хэл аялгууны томоохон дурсгал болохын зэрэгцээ эртний монгол хэлний онцлогийг уламжлан хадгалснаараа монгол хэлний үгийн сангийн өөрчлөлтийг түүхчлэн харуулах тодорхой баримт болж байна. Иймд түүний орчуулгын арвин их дурсгалын үгийн сангийн бүрэлдэхүүнийг нарийвчлан судлах нь монгол хэлний харьцангуй эрт үеийн үгсийн утга, үүрэг, хэрэглээг түүхчлэн тогтооход чухал ач холбогдолтой төдийгүй монгол хэлний үгийн санг сэргээн баяжуулахад зохих хувь нэмэр болох юм.

Цаашид Зая бандид Намхайжамцын орчуулсан дурсгалын үгийн санг бүртгэн багтаасан судалгаа хийх нь монгол хэлний түүхэн үгийн сангийн судлалын шийдэх ёстой ажлын нэг хэмээн үзэж байна. Бас өнөөгийн бидний үед учрыг нь тэр бүр мэдэхгүй болсон хуучин үгийн толь бичиг боловсруулж болохоос гадна орчин үед сэргээн хэрэглэх нь монгол хэл, түүх соёл сонирхон судлах хүмүүст тус нэмэр болохоор чухал ажил гэж үзэж байна.

## Товчлол

AG - xutuqtu suduriyin ayimagiyin erketü xān dēdū altan gerel kemēkü yeke kölgöni sudur (Тод үсгийн гар бичмэл судрын гэрэл зургийн хэвлэл. Эрхлэн хэвлүүлсэн Тод номын гэрэл төв. 2009, Улаанбаатар)

BMÜ - Bodhi möriyin üye orošiboī. (Тод үсгийн гар бичмэл судрын гэрэл зургийн хэвлэл. Эрхлэн хэвлүүлсэн Тод номын гэрэл төв. 2017, Улаанбаатар)

BSYO - Bodhi-sadva-yin yabudal-du oroxui (Лувсанбалдан, 1976, 318-330)

BT - The Commentary of Bodhicaryāvatāra by Chos-kyi ‘od-zer (1312)  
(Tumurtogoo, 2006, 50-60)

|          |                                                                                                                                                                                           |
|----------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| MNT      | - Mongqol-un niuča to[b]ča'an (Rachewiltz, 1972; Kuribayashi 2009 )                                                                                                                       |
| MTT      | - Moloni toyini tuuji (Түвшинтөгс, 2018, 17-161)                                                                                                                                          |
| NMŠ      | - Nayiman mingyan šülüqtü (Тод үсгийн барын судар; Mingyad, Erdemtü. 2016, V)                                                                                                             |
| NT       | - Nom yarxui {Б.Амарсанаагийн хувийн цуглуулгад буй тод үсгийн гар бичмэл сударын гэрэл зураг, 319 хуудас}                                                                                |
| PR (Col) | - Pañza_rakša (төгсгөлийн шүлэг) {Хувийн цуглуулгад буй тод үсгийн гар бичмэл судар, ca-9v-11r}                                                                                           |
| SNES     | - Sayitur nomloxui erdeniyin sang (Лувсанбалдан, 1976, 64-98)                                                                                                                             |
| SRN      | - Subhāṣitaratnanidhi, Dictionary of Sonom Gara's Erdeni-yin Sang (Kara, 2009)                                                                                                            |
| Sub.     | - Subhāṣitaratnanidhi by Sonom Gara (Ligeti, 1948, 1-124)                                                                                                                                 |
| TČ (Col) | - Tarpa_čenpo (төгсгөлийн шүлэг) {Хутуqtu yeke toniluqsani jüqtü delgeröölüqçi kemēkü yeke kölgöni sudur orošiboi} Хувийн цуглуулгад буй тод үсгийн гар бичмэл судар, 89v-90r.            |
| Tib.     | - Төвөд бичиг                                                                                                                                                                             |
| Tod.     | - Тод үсэг                                                                                                                                                                                |
| Turf. 6  | - Turfan-Collections, 6-A Poem about Destiny (Tumurtogoo, 2006, 85-86)                                                                                                                    |
| UÜ       | - aršāni jüreken nayiman üyetü niyuuča ubadišiyin ündüsün-ēče yurbaduγar keseqleqsen ubadis ündüsün kemēkü orošiboi. Тод үсгийн гар бичмэлийн гэрэл зураг (Mingyad, Erdemtü, 2016, 3-259) |

## Ном зүй

- Голстунский К.Ф. (1893). *Монгольско-русский словарь*, составленный профессором С.-Петербургского университета К. Ф. Голстунским. Том третий. СПб.,
- Лувсанбалдан Х. (1976). *Тод үсгийн дурсгалууд*. Ред. А. Лувсандэндэв. CORPUS SCRIPTORUM MONGOLORUM, T. XIX, F-14 УБ.: ШУАХ
- ОЦМХУССУ. (1986). *Орчин цагийн монгол хэлний үсгийн сангийн судлалын үндэс*. Улаанбаатар.
- Төмөртоого Д. (2011). *Монгол хэлний бичигийн дурасгалуудын үгийн бүтэцийн харьцуулсан судалгаа*. Улаанбаатар.
- Төмөрцэрэн Ж. (1974). *Монгол хэлний үгийн сангийн судлал*. Улаанбаатар.
- Түвшинтөгс Б. (2018) *Молон тойн эхээ тамаас гаргасан судар оршив*. Bibliotheca Oiratica-LXXVI, Улаанбаатар.
- Тэрбиш Л. (2018). *Төвд-Монгол иж бүрэн толь бичиг*. Улаанбаатар.
- Cleaves F.W. (1954). *The Bodistw-a Čari-a Awatar-un Tayilbur of 1312 by Čosgi Odsir*. Harvard Journal of Asiatic Studies, Vol. 17, No. 1/2.
- Kara György. (2009). *Dictionary of Sonom Gara's Erdeni-yin Sang. A Middle Mongol Version of the Tibetan Sa skya Legs bshad. Mongol-English-Tibetan*. With the assistance of Marta Kiripolská. Brill, Leiden-Boston.
- Kuribayashi H. (2009). Word-Index to the Secret History of the Mongols with Chinese Transcriptions and Glosses. (CNEAS Monograph Series 33.) Sendai.
- Ligeti L. (1948). *Le Subhasitaratnanidhi mongol, un document du moyen mongol, Partie I<sup>re</sup>*. Le manuscrit tibéto-mongol en reproduction phototypique avec une introduction {*Bibliotheca Orientalis Hungarica* VI} Budapest.
- Mingyad Erdemtü. (2016) *Ili-yin γool-un urusqal dayu oron-du qadaγalaγdaγu bayiy-a todū üsüg-un surbulji bičig-un čiyulγan* - 2, Öbür mongγol-un soyol-un keblel-un qoriy-a [Илийн голын урсгал дугуу оронд хадгалагдаж байгаа тод үсгийн сурвалж бичгийн чуулган-2, Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо]
- Rachewiltz I. de, (1972) *Index To The Secret History of the Mongols*. Indiana University, Bloomington.
- Tumurtogoo D. (2006). *Mongolian Monuments in Uighur-Mongolian Script (XIII-XVI Centuries): Introduction, Transcription and Bibliography*. With the Collaboration of G.Cecegdari. (*Language and Linguistics Monograph Series A-11.*) Institute of Linguistics, Academia Sinica, Taipei.

## **Abstract**

The Todo script monuments are one of the various monuments written in the Mongolian language and script. Among the major monuments of Todo script, the texts translated by Zaya pandita Namkhajamts hold a remarkable position. The monuments of those translations have been handed down in a small number of Uyghur-Mongolian script, mostly in Todo script. Contains a rich vocabulary of the native Mongolian language from the 17<sup>th</sup> century and earlier. Zaya pandita Namkhajamts's translated literary monuments contains numerous old words that aren't frequently used in the modern Mongolian language, both orally and in writing and have been transferred to the passive (archaic) vocabulary. Those words are considered in two parts: ancient words and obsolete words, and as an example, the meanings of some words are clarified with similar words in the active use of the modern Mongolian language.